



МОНГОЛ УЛС
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 11 өдөр

Дугаар 1/514

Чингис хот

Урьдчилан сэргийлэх арга хэмжээг
эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29,2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, Улсын Онцгой комиссын 2020 оны 12 дугаар тогтоол, Зам тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 161 дүгээр тушаалаар батлагдсан "Авто зам, замын байгууламжийг хаах, замын чиглэл өөрчлөх журам"-ын 1.4, аймгийн Онцгой комиссын № 32 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавирусын халдвар /COVID-19/-ын батлагдсан тохиолдол илэрсэнтэй холбогдуулан Улаанбаатар хотоос орох зорчигч тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 14:00 цагаас 11 дүгээр сарын 13-ны өдрийн 24:00 цаг хүртэлх хугацаанд хязгаарласугай.

2. Бүх шатны боловсролын байгууллага, сургалтын төвийн үйл ажиллагааг 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрөөс 11 дүгээр сарын 14-ний өдрийг хүртэл түр зогсоосугай.

3. Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд архи, согтууруулах ундааг худалдан борлуулах, түүгээр үйлчлэх үйл ажиллагааг 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрөөс 11 дүгээр сарын 14-ний өдрийг хүртэлх хугацаанд зогсоосугай.

4. Үзвэр үйлчилгээний газрууд болон олон нийтийг хамарсан төрөл бүрийн арга хэмжээг харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд тогтоосон хугацаагаар хязгаарлахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

5. Өндөржүүлсэн бэлэн байдлын үед халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдөж, олон нийтийн газарт зорчих үедээ гар ариутгагч хэрэглэн амны хаалт тогтмол зүүхийг аймгийн нийт иргэдэд, бараа үйлчилгээний үнийн хөөрөгдөл, зохиомол хомсдол үүсгэхгүй байж, халдвар хамгааллын дэглэмийг мөрдлөг болгон ажиллахыг хувиараа хөдөлмөр эрхэлж буй иргэд, аж ахуйн нэгж байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

6. Коронавирусын халдвар /COVID-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд иргэдэд халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлэн хяналт тавьж, зөрчигчдөд холбогдох хуулийн дагуу хариуцлага

231010907


2.

хүлээлгэж /тусгай зөвшөөрлийг цуцлах/ ажилла ыг Мэргэжлийн хяналтын газар /Б.Сүнгээ/, Эрүүл мэндийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Д.Баасандорж/, Онцгой байдлын газар /дэд хурандаа Ж.Эрдэнэбат/, Цагдаагийн газар /хурандаа Б.Батсайхан/, сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

7. Коронавируст халдвар /COVID-19/-ын батлагдсан тохиолдол Улаанбаатар хотод 2020 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр бүртгэгдсэнтэй холбогдуулан тухайн тохиолдлын хавьтал бүхий иргэдийн судалгааг гаргаж, эрүүл мэндийн үзлэгт хамруулан хяналт тавьж ажиллахыг Тагнуулын хэлтэс /дэд хурандаа Н.Алтангэрэл/, сумдын Онцгой комисс, Эрүүл мэндийн байгууллагуудын дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

8. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Ц.Чогсомжав/ Шуурхай штабын дарга /дэд хурандаа Ж.Эрдэнэбат/-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

The image shows a red official stamp of the Citizens' Khural of the Tsetserleg Sum. The stamp contains the text 'Төрийн захирлын Тамга' (State Emblem) and 'Төрийн захирлын Тамга' (State Emblem). A handwritten signature in black ink is written over the stamp. The signature appears to be 'Ц.ИДЭРБАТ'.

Ц.ИДЭРБАТ